

Баптисмын гэрээнүүд

Чи баптисм хүртэх үедээ Тэнгэрлэг Эцэгтэй гэрээ байгуулах буюу амлалтуудыг авдаг. Тэдгээр амлалтын заримыг жагсаавал:



- Есүс Христийг дагах (2 Нифай 31:13)
- Зарлигуудыг дуулгавартай дагах (Мозая 5:8)
- Бусдад тусалж, тэднийг тайтгаруулах (Мозая 18:8-9)

Тэнгэрлэг Эцэгийн хариуд нь амладаг зарим адислалыг дурдвал:

- Нүглийг чинь өршөөх (Үйлс 2:38)
- Чамайг Ариун Сүнстэй хамт байхаар адислах (Сургаал ба Гэрээ 20:77)
- Өөртэй нь хамт амьдрахаар буцаж ирэхэд туслах (Алма 7:15-16)

Та нар Есүс Христийг дагах замдаа гайхалтай адислалуудыг авах болно!

Амлалтуудаа сахих нь

Хэн нэгэнд тусалсан үе . . .

Есүсийн жишээг дагасан үе . . .

Зөвийг сонгосон үе . . .